

БАТЛАВ:

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ДАРГА



С.МӨНХНАСАН

БАТЛАВ:

ИНТЕРАКТИВ ХХК
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Б.УУГАНБАЯР

VERITECH ERP СИСТЕМИЙН ДЭМЖЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

2022 оны 08 дугаар сарын 23

№ 22/v33
ХНХС 34/22

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Регистрийн 2628546 дугаарт бүртгэлтэй Монгол Улсын хуулийн этгээд болох **ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР** (цаашид **Захиалагч** гэх), нөгөө талаас Регистрийн 2097192 дугаарт бүртгэлтэй **ИНТЕРАКТИВ ХХК**, (цаашид **Гүйцэтгэгч** гэх, хамтад нь **Талууд** гэх) нар Монгол Улсын Иргэний хуулийн нийтлэг үндэслэл, 343-358 дугаар зүйлд заасан үндэслэл, журмыг баримтлан дор дурдсан нөхцөлөөр байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь захиалагч талд ИНЕГ/ЦА/ТББ/Ү-05/15 тоот гэрээний хүрээнд нийлүүлсэн “Санхүү, нягтлан бодох бүртгэл, төсөв төлөвлөлт, цалингийн удирдагын систем, цаг бүртгэлийн систем, гэрээний удирдлагын систем, төслийн удирдлагын систем, худалдан авалтын удирдлагын систем, санхүүгийн шинжилгээ, дотоод захиалга, хангамжийн систем, хүний нөөцийн удирдлагын систем болон үндсэн хөрөнгийн тооллогын системүүд”-ийг ашиглах хүрээнд системийн хэвийн ажиллагааг буюу системээс хамаарсан технологийн доголдолгүй, хууль дүрэм журамтай холбоотой нэмэлт өөрчлөлт болон платформын шинэчлэлтийг хийж, ажиллах явцад үүсэх талуудын хоорондын харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Талууд гэрээний үүргээ бодитоор биелүүлэх, түргэн шуурхай үйлчлэх, ажил хэргийн ёс зүйтэй харилцах, оюуны өмч, зохиогчийн эрхийг дээдлэх зарчмыг удирдлага болгоно.
- 1.3 Энэхүү гэрээ нь дараах хавсралтуудын хамт хүчин төгөлдөр болно
 - 1.3.1. Хавсралт 1 – Талуудыг төлөөлөн ажиллах ажилтнуудын холбогдох мэдээлэл
 - 1.3.2. Хавсралт 2 – Гүйцэтгэгчийн нэмэлт ажлын үйлчилгээний үнэ, тарифын жагсаалт
 - 1.3.3. Хавсралт 3 – Улиралд үзүүлсэн үйлчилгээг тайлагнах тайлангийн загвар
 - 1.3.4. Хавсралт 4 – Нэмэлт ажлыг гүйцэтгэн хүлээлцэх актын загвар
 - 1.3.5. Хавсралт 5 – API гаргах жагсаалт

Хоёр. Гүйцэтгэх ажил үйлчилгээний төрөл, үйлчилгээ үзүүлэх хэлбэр, хугацаа

- 2.1 Гүйцэтгэгч нь гэрээний хугацаанд захиалагчид суурилуулж, актаар хүлээлгэн өгсөн гэрээний 1.1-д заасан системийг ашиглах, үйл ажиллагаандаа хэрэглэхтэй холбоотой дараах мэргэжлийн туслалцаа, үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:
 - 2.1.1 Системийн сүүлийн үеийн мэдээлэл, боломжууд түүнтэй холбоотой мэдээллээр хангах;
 - 2.1.2 Платформ технологийн шинэчлэлт хийх (version upgrade);
 - 2.1.3 Хууль тогтоомж /хууль, дүрэм, журам, тогтоол, акт гэх мэт/ -д орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу системд хийгдэх нэмэлт хөгжүүлэлт хийх;
 - 2.1.4 Гүйцэтгэгчийн зүгээс уг гэрээний 2.1.3-т заасан хүрээнд хэрэглэгчдэд зориулан хийсэн системийн сайжруулалт, шинэчлэлтийг ашиглах;

- 2.1.5 Системийн ажиллагаатай холбоотой гарсан алдаа, доголдлыг илрүүлэх, засварлах;
- 2.1.6 Нийлүүлэгч нь системээс энэхүү гэрээний 5 дугаар хавсралтад заагдсан өгөгдөл, мэдээллийг үйлчлүүлэгч талын дотоод үйл ажиллагаанд ашиглагддаг системд дамжуулах API сервис бэлтгэж өгнө;
- 2.1.7 Гүйцэтгэгч нь системд Захиалагч талын олон хэрэглэгчдэд ашиглагдах дэд системүүд, модулиуд, үйлдлүүдэд өөрчлөлт, шинэчлэлт хийсэн бол урьдчилж Захиалагч талын томилогдсон ажилтнуудаар тест туршилт хийлгэж зөвшөөрөл авсны дараа үндсэн системд оруулна;
- 2.1.8 Тухайн хувилбарын сүүлийн байдлаарх гарын авлага материалаар хангах; (PDF, системийн тусламж хэсэгт дэх контент)
- 2.1.9 Сервер унтарсан, ажиллахгүй болсон үед онлайнаар шалгах, зөвлөгөө өгөх;
- 2.1.10 Системийг хүлээлгэн өгсөн сүүлийн байдлаар системийн хэвийн ажиллагааг хангах, технологийн болон системээс хамаарсан алдаа, доголдолгүй, бүртгэлийг хэвийн ажиллуулах;
- 2.2 Гүйцэтгэгч нь гэрээний 2.1-д заасан ажил үйлчилгээг дараах хэлбэрээр үзүүлнэ. Үүнд:
- 2.2.1 **CALL CENTER** буюу 7777-8282-1 дугаарын утсаар санал, хүсэлт хүлээн авах, мэдээлэл, зөвлөгөө өгөх ажилтныг ажлын өдрүүдэд 09.00-18.00 цагийн хооронд ажиллуулах,
- 2.2.2 **HELP DESK** буюу засварын системээр дамжуулан санал, хүсэлт хүлээн авах, мэдээлэл, зөвлөгөө өгөх, засвар хийх ажилтныг ажлын өдрүүдэд 09.00-18.00 цагийн хооронд ажиллуулах бөгөөд аливаа асуудлыг заавал helpdesk.veritech.mn цахим хуудсанд бүртгэлжүүлэх,
- 2.2.3 Шаардлагатай тохиолдолд буюу систем нэвтрэх боломжгүй болсон, заавал биеэр шалгах шаардлагатай тохиолдолд захиалагчийн ажлын байранд хүрэлцэн очиж, зөвлөгөө өгөх, засвар үйлчилгээ хийх ажилтныг томилон ажиллуулах.
- 2.3 Гүйцэтгэгч нь Call center болон Helpdesk системээр хүлээн авсан санал, хүсэлтэд тухайн ажлын өдөртөө багтааж, заавал хариу мэдэгдэх ба захиалагчид учирсан аливаа системийн алдаа, дутагдлыг шийдвэрлэхийн тулд шаардлагатай мэргэжлийн туслалцааг үзүүлэн ажиллана.
- 2.4 Гүйцэтгэгч нь Call center болон Helpdesk системээр шийдвэрлэх боломжгүй байгаа нөхцөлд буюу уг гэрээний 2.2.3-т заасан нөхцөлд нэвтрүүлэлт, үйлчилгээний хэлтсийн ажилтанг захиалагчийн ажлын байранд очиж, засвар үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлэхээр томилон ажиллуулна.
- 2.4.1 Гүйцэтгэгчийн зүгээс Захиалагч талыг хариуцсан ажилтанг гэрээний хугацаанд томилж өгөх ба тухайн ажилтан захиалагчийн түлхүүр хэрэглэгчтэй холбогдож ажиллана. Уг ажилтнуудыг хоёр талаас томилж, баталгаажуулна.
- 2.5 Энэхүү гэрээ нь 2022 оны 08-р сарын 23-ны өдрөөс 2023 оны 08 дугаар сар 23-ний өдрийг хүртэлх хугацаанд буюу 1-жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Гурав. Гэрээний үнэ ба төлбөрийн нөхцөл

- 3.1 Гэрээний хугацаанд үзүүлэх үйлчилгээний нийт төлбөр нь 19,800,000₮ (арван есөн сая найман зуун мянга) төгрөг байна.
- 3.2 Талуудаас томилогдсон ажилтнууд гэрээг гурван сар тутам буюу улирал бүр дүгнэж, хавсралт 3-т оруулсан загварын дагуу хоёр талаас баталгаажуулна.
- 3.3 Гэрээний төлбөрийг захиалагч тал нь энэхүү гэрээг байгуулсан өдрөөс хойш доорх хуваарийн дагуу төлж барагдуулна.

№	Төлбөрийн нөхцөл	Дүн
1	Гэрээ байгуулсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор гэрээний нийт төлбөрийн 50 хувийг	9,900,000

2	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 6 сарын дараа Гүйцэтгэгчийн бэлтгэсэн ажлын тайланг баталгаажуулснаар	9,900,000
Нийт		19,800,000

- 3.4 Харилцагч тал гэрээнд заасан төлбөр тооцоог 3.3-т заасан нөхцлийн дагуу Гүйцэтгэгч талын ХАС банкны **5002 605 946** тоот төгрөгийн дансанд шилжүүлнэ.
- 3.5 Системийн үндсэн модулийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц өөрчлөлт буюу цоо шинэ нэмэлт хөгжүүлэлт (үүнд системийг хүлээлгэн өгсөн актан д заасан процесс, модуль, хуулийн болон технологийн шинэчлэлтийн хүрээнд хийгдсэн нэмэлт боломжууд, системийн байх стандарт процессоос бусад хөгжүүлэлт буюу системд шинээр хийгдэх нийт ажил хамаарна) болон гэрээний 2.1-т зааснаас бусад нэмэлтээр хийгдэх ажлыг буюу системийн хэвийн ажиллагааг хангахаас бусад гэх мэт тухайн ажлын цар хүрээ, гүйцэтгэх хугацаа зэргийг харгалзан үзэж, ажлыг нэмэлт төлбөртэйгээр гүйцэтгэнэ. Нэмэлт хөгжүүлэлтийн хувьд системийн стандарт процесс, бүртгэлд ороогүй, хамаарахгүй шинэ бүртгэлийг захиалагчийн санаачилга, захиалгаар хийх бөгөөд аливаа хүсэлтийг Гүйцэтгэгч анализ хийн нэмэлт хөгжүүлэлт шаардлагатай эсэх дээр тайлбар өгч, хоёр талаас баталгаажуулан гүйцэтгэх боломжтой.
- 3.6 Гэрээний 3.5-д заасан нэмэлт ажлыг тооцоолох төлбөрийн үнэлгээ нь нэвтрүүлэлт, сургалт үйлчилгээний 1 хүн цагийн үнэлгээ 17,000 /НӨАТ-гүй/ төгрөг, нэмэлт хөгжүүлэлтийн үнэлгээ 1 хүн/өдөр 227,000 /НӨАТ-гүй/ төгрөг байна. Гүйцэтгэгч нь тухайн нэмэлт ажлыг гүйцэтгэх хугацаа болон ажлын жагсаалтыг захиалагчид танилцуулж, хавсралт 1-т заасан ажилтнууд бичгээр баталгаажуулсанаар тухайн ажлыг гүйцэтгэх, төлбөр төлөх боломжтой болно.
- 3.7 Гэрээний 3.5-т заасан нэмэлт үйлчилгээ гэдэгт системийн өмнөх ажлын урсгалын тохиргоо, систем дээр гарсан алдааг олж тохируулж, зөвлөгөө өгөх, системийн технологийн шинэчлэлттэй холбоотой хэсэгт нэмэлт сургалт зөвлөгөө өгөх, гарын авлагаар хангах болон сервертэй холбоотой зөвлөгөө онлайн байдлаар өгөх зэрэг үйлчилгээ хамаарахгүй. Мөн нэмэлт хөгжүүлэлтийн хувьд систем дээр шинээр өмнө хийсэн тохиргоог шалгаж хэвийн болгох, нийлүүлэгчийн буруутайгаас гарсан алдааг засч сайжруулах зэрэг хамаарахгүй бөгөөд захиалагч талын хүсэлтээр ирсэн шаардлагыг хоёр талаас баталгаажуулсан шаардлагыг хэлнэ.
- 3.8 Гэрээний 3.5-д заасан нэмэлт ажлыг тооцоолох нэг удаагийн төлбөрийн үнэлгээний дээд хэмжээ нийт гэрээний үнийн дүнгээс хэтрэхгүй байх бөгөөд хэрэв хэтрэхээр бол тухайн ажлыг хойшлуулна.
- 3.9 Хэрэв ажлын хэрэгцээ шаардлагаар хэрэглэгчийн тоог нэмэх, шинэ систем нэмэх бол энэ талаар Гүйцэтгэгч талтай тохиролцож, тусдаа нэмэлт гэрээ байгуулж ажиллана.
- 3.10 Захиалагч нь төлбөрийг тогтсон хугацаанд төлөх үүрэгтэй бөгөөд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1%-ийн алдангийг төлнө.

Дөрөв. Талуудын эрх, үүрэг

- 4.1 Гүйцэтгэгч нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
- 4.1.1 Захиалагчээс гэрээний төлбөрөө хугацаандаа төлөхийг шаардах.
- 4.1.2 Гэрээний төлбөрөө хугацаандаа төлөөгүй бол төлөх хүртэл Үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, гэрээнд заасан арга хэмжээг авах, эсхүл гэрээг цуцлах.
- 4.1.3 Гүйцэтгэгчийн зохиогчийн эрхийг хүндэтгэж хуулийн дагуу ажиллахыг шаардах, зөрчил гаргасан тохиолдолд зөрчлийг арилгахыг шаардах, учирсан хохирлоо нэхэмжлэх.
- 4.1.4 Захиалагчээс гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах.,
- 4.1.5 Гэрээгээр хүлээсэн үүргээ түргэн шуурхай гүйцэтгэх үүрэгтэй.
- 4.1.6 Үйлчилгээг гэрээнд заасан хэлбэр, цагийн хуваарийн дагуу гэрээний хугацаанд тасралтгүй үзүүлэх үүрэгтэй.

- 4.1.7 Захиалагчээс хүсэлт гаргасан, эсхүл тухайн үйлчилгээг Захиалагчийн ажлын байранд очиж гүйцэтгэх шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжилтнийг томилон ажиллуулах үүрэгтэй.
- 4.1.8 Захиалагчээс ирүүлсэн хүсэлтийг нийтдээ ажлын 3 хоногт, үйлчилгээ болон Гүйцэтгэгчийн ажилтантай холбоотой гомдлыг нийтдээ ажлын 5 хоногийн дотор шийдвэрлэх бөгөөд алдааг гэрээний 4.1.9-д заасны дагуу хугацаанд шийднэ.
- 4.1.9 Гүйцэтгэгч нь системд алдаа гаргахгүйг чармайн ажиллах бөгөөд алдаа гарсан тохиолдолд дараах ангилалын дагуу шуурхай шийдвэрлэж ажиллана

Асуудлын ангилал	Тодорхойлолт	Ажлын цар хүрээ	Хариу арга хэмжээ авах хугацаа			Гүйцэтгэгч талын хариуцах ажилтан
			Хүлээн авах, оношлох цаг	Ажлын бүс цаг	Шийдвэрлэх хугацаа /ажлын/	
Алдаа, доголдол	Ноцтой алдаа	Систем бүрэн болон хэсэгчилэн зогссон	1 цаг	Дараагийн ажлын өдөр эхэлснээс хойш 2 цагийн дотор	8 цаг	Хасвралт 1г заасан талуудын ажилтнууд
		Системийн бүртгэлийн цааш үргэжлүүлэх боломжгүй том хэмжээний алдаа				
		Системийн модулийн хэвийн ажиллагаа алдагдсанаас Захиалагч тал санхүүгийн эрсдэл хүлээх нөхцөл байдал үүссэн				
	Бусад алдаа	Системийн модулийн хэвийн ажиллагаа алдагдсанаас өдөр тутмын ажилд саад учруулсан технологийн алдаа	8 цаг	Дараагийн ажлын өдөр эхэлснээс хойш 8 цагийн дотор	/Гүйцэтгэгч тал болон захиалагч тал харилцан тохиролцож болно/	

		Системийн бүртгэл, эрхийн тохиргоо болон бусад алдаа	8 цаг	Дараагийн ажлын өдөр эхэлснээс хойш 8 цагийн дотор	/Гүйцэтгэгч тал болон захиалагч тал харилцан тохиролцох бөгөөд төлбөртэйг өөр гүйцэтгэх эсэхийг гэрээнд заасны дагуу шийдвэрлэх/	Хасвралт 1т заасан талуудын ажилтнууд
--	--	---	-------	--	--	--

- 4.1.10 Гүйцэтгэгч нь захиалагчийн бизнесийн нэр хүнд, гэрээт ажлыг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн мэдээллийн нууцлалыг чанд хадгалах үүрэгтэй.
- 4.1.11 Гүйцэтгэгч нь захиалагчийн санал хүсэлтийг гэрээний 4.1.8 болон 2.4-т заасны дагуу хүлээн авч шийдвэрлэх бөгөөд аливаа шинэчлэлт, өөрчлөлтийг талууд тохиролцож, гүйцэтгэснээс хойш 7 хоногийн дотор тухайн шинэчлэлттэй холбоотой сургалтыг зохион байгуулж, гарын авлага мэдээллийг захиалагчид хүлээлгэн өгнө.
- 4.1.12 Үндсэн гэрээ (ИНЕГ/ЦА/ТББ/Ү-05/15)-нд туссан систем буюу гэрээний 1.2-т заасан түүнтэй холбоотой шаардлагатай шинэчлэлт сайжруулалтыг /системийн суурь upgrade/ энэхүү гэрээний хүрээнд нэмэлт төлбөргүйгээр гүйцэтгэнэ,
- 4.1.13 Гүйцэтгэгч нь жилд нэг удаа системийн шинэчлэлт / гэрээний 2.1.2, 2.1.3-т заасан/ хийх бөгөөд шинэчлэлт хийх хугацаанд захиалагчтэй тохирч сургалтыг онлайн эсвэл биет байдлаар хийнэ.
- 4.1.14 Хууль болон гэрээнд заасан бусад эрх, үүрэг,
- 4.2 Захиалагч нь дараах эрхтэй, үүрэгтэй. Үүнд:
- 4.2.1 Гэрээнд заасан ажил, үйлчилгээгээр хангуулахаар санал хүсэлт гаргах, зөвлөгөө хүсэх, системийн тохиргоо, засвар үйлчилгээ хийлгүүлэх эрхтэй ба гэрээний 2.1-т зааснаас бусад үйлчилгээг гэрээний 3.5 болон 3.6-д заасны дагуу тохиролцон үйлчилгээг авах, актаар хүлээлцэх эрхтэй.
- 4.2.2 Захиалагч нь нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын стандарт, Татвар, нийгмийн даатгалын хууль, тогтоомжинд өөрчлөлт шинэчлэл орох бүрт хэрэгжиж эхлэх хугацаанаас нь өмнө Гүйцэтгэгчид мэдэгдэж, эдгээр өөрчлөлтүүдийг системд тусгаж, өөрчлөлт оруулах талаар хүсэлт гаргах эрхтэй.
- 4.2.3 Гэрээний үүргээ хугацаандаа биелүүлэхийг Гүйцэтгэгч талаас шаардах эрхтэй,
- 4.2.4 Гэрээнд заасан хэлбэр, цагийн хуваарийн дагуу Үйлчилгээ үзүүлэхийг шаардах, үйлчилгээнд хяналт тавих эрхтэй,
- 4.2.5 Гүйцэтгэгчийн ажилтан болон үйлчилгээтэй холбоотой гомдлыг шууд удирдах албан тушаалтанд гаргаж, шийдвэрлүүлэх эрхтэй,
- 4.2.6 Үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөх, хугацаа хэтрүүлсэн тохиолдолд гэрээнд заасан хэмжээгээр алданги төлөх үүрэгтэй,

- 4.2.7 Захиалагч, түүний ажилтан үйлчилгээ авах хүсэлтээ тухай бүр HELP DESK системд хүсэлт гаргасан хугацаа, хүсэлтийн дугаар, төлөв, төрөл, хэрэглэгчийн шийдвэрлэвэл зохих зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг бүртгүүлж, хүсэлт гаргах үүрэгтэй.
- 4.2.8 Захиалагч, түүний ажилтан үйлчилгээ авах, үйлчилгээтэй холбоотой гомдол гаргах, гэрээний дагуу Гүйцэтгэгчтэй харилцахдаа ажил хэргийн ёс зүйг баримтлан харилцах, аливаа шаардлагаа зөв боловсон тавьж шийдвэрлүүлэх үүрэгтэй.
- 4.2.9 Системтэй холбоотой Гүйцэтгэгчийн оюуны өмч, зохиогчийн эрхийг зөрчихгүй байх, цааш дамжуулан хуулбарлах, систем нийлүүлэх гэрээнд зааснаас олон тооны компьютерт суурилуулах, өөр бусад байгууллагад ашиглуулахгүй байх үүрэгтэй ба зөрчсөн тохиолдолд учирсан хохирлыг зөвшөөрөлгүй суурилуулсан хэрэглэгчийн тоогоор тооцож, нөхөн төлөх үүрэгтэй,
- 4.2.10 Захиалагч нь хөдөө, орон нутагт байрлалтай бол Гүйцэтгэгч талаас гарах замын зардлыг бүрэн хариуцах үүрэгтэй.
- 4.2.11 Захиалагчид ашиглагдаж байгаа системийн мэдээллийн бааз гадны нөлөөллөөс (програм суулгаж, компьютер вирустэх, цахилгааны хэлбэлзлээс компьютерын хатуу диск эвдрэх, харилцагчийн буруутай үйл ажиллагаа, цахим халдлагад өртөх болон бусад) болж устгах, мэдээлэл дахин сэргээгдэхгүй болох г.м асуудлыг Гүйцэтгэгч тал хариуцахгүй.

Тав. Гэрээ дуусгавар болох, цуцлах

- 5.1 Энэхүү гэрээ нь тохирсон хугацаа дууссан, гэрээнд заасан үүргээ биелүүлснээр дуусгавар болно.
- 5.2 Гэрээний хугацаа дууссан бөгөөд талуудын аль нэг нь гэрээг дуусгавар болох талаар нөгөө талдаа гэрээ дуусахаас 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдээгүй тохиолдолд гэрээний хугацааг дахин 1 жилээр сунгагдсан тооцно.
- 5.3 Талуудын аль нэг тал үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал үүргээ биелүүлэх тодорхой хугацаа зааж, шаардлага тавих бөгөөд тэр хугацаанд үүргээ биелүүлээгүй нөхцөлд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авч болно.
- 5.4 Хэрэв захиалагч тал хууль бусаар системийн лицензийг ашигласан, гуравдагч этгээдэд дамжуулсан болон Гүйцэтгэгч талын нууцад хамаарах мэдээ, материал, систем, платформын хэрэгслүүд, эх код, техникийн бичиг баримтыг задруулсан тохиолдолд урьдчилан мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор зохих арга хэмжээг авч, гэрээг цуцалж, хохирлыг барагдуулах арга хэмжээ авах үүрэгтэй.
- 5.5 Талуудын үүргийн биелэлтийг нягтлан шалгаж, аль нэг талын гүйцэтгээгүй, дутуу гүйцэтгэсэн гэж дүгнэвэл хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1%-ийн алдангийг төлнө. Энэхүү үүргийн биелэлтийг гэрээний хавсралт 3-т заасан тайлан болон гэрээний хавсралт 4-т заасан актаар дүгнэнэ.
- 5.6 Аль нэг тал дампуурсан эсвэл татан буугдсан бол гэрээ цуцлагдана.

Зургаа. Бусад

- 6.1 Энэхүү гэрээнд Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 6.2 Талууд гэрээ байгуулсантай холбогдон шууд болон шууд бусаар мэдсэн, олж авсан, талуудтай холбоотой бизнесийн нууцад хамаарах аливаа мэдээ, мэдээлэл, баримтыг нөгөө талын зөвшөөрөлгүйгээр өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд, эсвэл гэрээний нөгөө талын эсрэг ашиглахгүй, аливаа гуравдагч этгээдэд амаар буюу бичгээр задруулахгүй, дамжуулахгүй байх үүргийг хүлээнэ. Гэрээний нууцлалыг задруулбал учирсан хохирлыг буруутай тал нь үл маргах журмаар барагдуулна.

- 6.3 Гэрээний нэмэлт өөрчлөлт, хавсралт нь энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг бөгөөд талууд бичгээр үйлдэж, гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 6.4 Гэрээг 3 хувь үйлдэж, тус бүр Гүйцэтгэгч нэг, захиалагч хоёр хувийг хадгална.
- 6.5 Энэхүү гэрээ нь талуудын хувьд заавал биелүүлэх хүчин чадалтай баримт бичиг болно.
- 6.6 Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар гэрээний өмнөх аман гэрээ, хэлэлцээр, тохиролцоо, санал хүчингүй болно.
- 6.7 Захиалагч, Гүйцэтгэгчийн аль аль нь энэ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

Захиалагч талыг төлөөлж:

Гүйцэтгэгч талыг төлөөлж:

“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР”


"ИНТЕРАКТИВ" ХХК

Захиргаа, удирдлагын газрын дарга

Нэвтрүүлэлт, үйлчилгээний албаны дарга



Т.Батжаргал



Б. Мөнхсоёл

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга

Борлуулалтын албаны дарга




Д.Хатанбаатар



Б.Гангамөрөн

Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын газрын дарга

Хаяг: СБД, Бага тойруу-49, Мэдээллийн технологийн үндэсний парк, урд корпус.



П.Ариунболд

Утас:+976 88108955

Хаяг: Хан – Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Буянт – Ухаа, Улаанбаатар

Утас:

Талуудыг төлөөлөн ажиллах ажилтнуудын холбогдох мэдээлэл

Агуулга	Гүйцэтгэгч	Захиалагч
Гэрээний асуудлаар		
Хариуцах хүний нэр:	Б.Гангамөрөн	
Албан тушаал:	Борлуулалтын албаны дарга	
E-mail:	gangamurun@interactive.mn	
Гар утас:	88108955	
Төслийн талаарх асуудлаар		
Хариуцах хүний нэр:	Т.Гантулга	
Албан тушаал:	Төслийн менежер	
E-mail:	gantulga@interactive.mn	
Гар утас:	88066535	
Нэвтрүүлэлт, үйлчилгээний талаарх асуудлаар		
Хариуцах хүний нэр:	Б.Мөнхсоёл	
Албан тушаал:	Нэвтрүүлэлт, үйлчилгээний албаны дарга	
E-mail:	gantulga@interactive.mn	
Гар утас:	88029673	
Бусад асуудлаар Интерактив компанитай дараах хаягаар холбоо барина.		
Хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-49, Мэдээллийн технологийн үндэсний парк, урд корпус.	
Утас:	976-77778282-1	
Имэйл:	info@interactive.mn	
Вэб хуудас:	www.interactive.mn , www.veritech.mn	

Гүйцэтгэгчийн нэмэлт ажлын үйлчилгээний үнэ, тарифын жагсаалт*

№	Үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ
1	Мэргэжлийн үйлчилгээ		
	Мэргэжлийн үйлчилгээний зардал нь тухайн байгууллагын хүсч буй нэмэлт шаардлага дээр үндэслэн систем дээр ажиллах хугацаанаас шалтгаалан тооцоологдоно.		
1.1	Бизнес процессын судалгаа, шинжилгээ, ре-инженеринг, GAP анализ, Roadmap гаргах, Сургалтын үйлчилгээ	Хүн/өдөр	320,000
1.2	Технологийн нэмэлт хөгжүүлэлт(мобайл хөгжүүлэлт г.м)	Хүн/өдөр	272,000
1.3	Мэдээллийн технологийн зовлогөө (сервер тоног төрөөрөмж г.м)	Хүн/өдөр	182,000
2	Нэвтрүүлэлт үйлчилгээ		
2.1	Өгөгдөл, мэдээлэл бүртгэл тохируулах	Хүн/өдөр	227,000
2.2	Серверийн Сүүрилүүлэлт, тохиргоо	Сервер бүрт	2,000,000
2.3	Процессын тохиргоо, конфигураци	Хүн/өдөр	227,000
2.4	Нэвтрүүлэлт үйлчилгээ	Хүн/цаг	17,000

*Энэхүү тариф нь гэрээ хүчинтэй хугацаанд өөрчлөгдөхгүй мөрдөгдөнө.

Улиралд үзүүлсэн үйлчилгээний гүйцэтгэлийг тайлагнах тайлангийн загвар

No.	Helpdesk дугаар	Систем	Модуль	Асуудлын ангилал (high/ mid/low)	Үүсгэсэн огноо	Шийдэх/ Тохиролцсон огноо	Шийдвэрлэсэн огноо	Хугацаа хэтэрсэн хоног	Баталгаажуулсан ажилтан
1									
2									
3									
...									

ТАЙЛАН БАТАЛСАН:

Захиалагч талыг төлөөлж:

.....

.....

.....

.....

Гүйцэтгэгч талыг төлөөлж:

ИНТЕРАКТИВ ХХК

Нэвтрүүлэлт, үйлчилгээний албаны дарга

.....

/Б.МЭНХСӨӨЛ /

НЭМЭЛТ АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ АКТ/ЗАГВАР/

Програм хангамжийн нэр	“.....”		
Гэрээний №	№.....	Гэрээний огноо	2022 оны ... сарын ... өдөр
Захиалагчийн мэдээлэл			
Нэр:			
Хаяг:	 Утас: (+976) 11-.....		
Гүйцэтгэгчийн мэдээлэл			
Нэр:	Интерактив ХХК		
Хаяг:	Мэдээлэл Технологийн Үндэсний Парк 109 тоот Бага тойруу 49, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс		
Гүйцэтгэл			
Гэрээнд заасан ажлын дагуу “Veritech ERP нэмэлт хөгжүүлэлт” ажлыг хүлээлгэн өгч байна.			
Хүлээлцсэн:			
Баталгаажуулсан			
Баримтыг баталгаажуулсан талуудын эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг			
..... ХХК	МТГ захирал /О...../ СХАХ захирал /...../ ПХХ захирал /...../		
Интерактив ХХК	Бүтээгдэхүүн хариуцсан менежер Нэвтрүүлэлтийн ажилтан _.....		

Veritech ERP системээс API сервис гаргаж өгөх өгөгдлүүднн жагсаалт болон өгөгдлийн авах нөхцөл.

№	Модулийн нэр	Төрөл	Өгөгдөл
1	Үндсэн хөрөнгө	Үндсэн хөрөнгө тус бүрийн өгөгдөл /Шинэ хөрөнгө хүлээн авах бүртгэх, эд хариуцагч эзэн солигдох бүрт мэдээллийг авч байх/	Төрөл
			Бүлэг
			Код
			Үндсэн хөрөнгийн нэр
			Баркод
			Сериал
			Эд хариуцагч
			Байршил /хөрөнгө байгаа барилга өрөө тоот/
			Ашиглах жил
			Баримтын төрөл
			Баримтын огноо
			Баримтын дугаар
			Харилцагчийн нэр, код
			Гэрээний нэр, код
			Үйлдвэрлэсэн улс
			Регистр
			Нэгж үнэ
2	Бараа	Бараа сэлбэг тус бүрийн өгөгдөл /Шинэ бараа хүлээн авах бүртгэх, ч эзэн солигдох бүрт мэдээллийг авч байх/	Нийт үнэ
			Хуримтлагдсан элэгдэл
			Төрөл
			Бүлэг
			Код
			Үндсэн хөрөнгийн нэр
			Баркод
			Сериал
			Байршил /хөрөнгө байгаа барилга өрөө тоот/
			Ашиглах жил
			Баримтын төрөл
			Баримтын огноо
			Баримтын дугаар
			Харилцагчийн нэр, код
			Гэрээний нэр, код
			Үйлдвэрлэсэн улс
3	Хүний нөөц	Ажилтаны хувийн мэдээлэл /Шинэ бүртгэл, хүн хасагдах, мэдээлэл	Регистр
			Нэгж үнэ
			Нийт үнэ
			Хуримтлагдсан элэгдэл
			Ажилтны код
			Овог
			Нэр
			Төрсөн огноо

		шинэчлэгдэх бүрт өгөгдлийг авч байх/	Хүйс
			Регистрийн дугаар
			Яс үндэс
			Гэр бүлтэй эсэх (тийм/үгүй)
			Хүүхдийн тоо
			Амьдран суугаа хаяг (Аймаг/дүүрэг, хороо/сум)
			Боловсролын зэрэг
			Мэргэжил
			Төгссөн он
		Албан тушаалтай холбоотой мэдээлэл	Одоогийн салбар нэгж
			Одоогийн албан тушаал
			Анх ажилд орсон огноо
			ИНЕГ-т Ажилласан жил
		/Албан тушаал солигдох бүрт тухайн ажилтны мэдээллийн шинэчлэж авч байх/	Хортой нөхцөлд ажиллаж байгаа эсэх
			Статус (ажиллаж байгаа эсэхтэй холбоотой)
		Цаг бүртгэл	Ажилтны код
			Ажилласан цаг
			Хоцорсон цаг
			Илүү цаг
		/Өдөрт нэг удаа бүх ажилтнуудын өгөгдлийг авч байх/	Огноо



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ГЭРЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

Гэрээний нэр	VERITECH ERP СИСТЕМИЙН ДЭМЖЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ
Гэрээний танилцуулга	Энэхүү гэрээнд "Санхүү, нягтлан бодох бүртгэл, төсөв төлөвлөлт, цалингийн удирдлагын систем, цаг бүртгэлийн систем, гэрээний удирдлагын систем, төслийн удирдлагын систем, худалдан авалтын удирдлагын систем, санхүүгийн шинжилгээ, дотоод захиалга, хангамжийн систем, хүний нөөцийн удирдлагын систем болон үндсэн хөрөнгийн тооллогын системүүд"-ийг ашиглах хүрээнд системийн хэвийн ажиллагааг буюу системээс хамаарсан технологийн доголдолгүй, хууль дүрэм журамтай холбоотой нэмэлт өөрчлөлт болон платформын шинэчлэлтийг хийж, ажиллах явцад үүсэх талуудын хоорондын харилцааг зохицуулахад оршино. Талууд гэрээний үүргээ бодитоор биелүүлэх, түргэн шуурхай үйлчлэх, ажил хэргийн ёс зүйтэй харилцах, оюуны өмч, зохиогчийн эрхийг дээдлэх зарчмыг удирдлага болгон хамтран ажиллана.
Газар, салбар, нэгжийн нэр	
Огноо	

Хянасан:
Албан тушаалтны нэр

Э. Мунуша

Э. Мунуша

Боловсруулсан:
Мэргэжилтний нэр

Ф

Т. Монкуур

Жич: Танилцуулга нь хууль тогтоомжид нийцсэн, тооцоо судалгаанд тулгуурласан, мэргэжлийн төвшинд үндэслэл сайтай, товч тодорхой бичигдсэн байна.